

Сангийн сайдын 2013 оны 05
дугаар сарын 31-ний өдрийн 125
дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ҮННИЙ САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛНАА)

2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт орсон.
ХУУЛЬ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
БОДЛОГЫН ГАЗАР

Улаанбаатар
2013 он

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэгчийг **харьцуулалтын аргаар** сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: www.e-procurement.mn

БАТЛАВ

“УБДС” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

2020 оны 04 дүгээр сарын 06

Тендерийн нэр: “СЕРВЕРИЙН ӨРГӨТГӨЛ ШИНЭЧЛЭЛТ”

Тендер шалгаруулалтын дугаар: ТЗБАХ-2020/07

Улаанбаатар

2020

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 05 дугаар сарын 21-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: “Серверийн өргөтгөл шинэчлэлт”

Тендер шалгаруулалтын дугаар: ТЗБАХ-2020/07

“УБДС” ТӨХК- нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Серверийн өргөтгөл шинэчлэлт”-ийн цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000 (тавин мянга)** төгрөгийг банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын шаардлагыг хангасан байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Үгүй**

Тендерийг **2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 10 цаг 30 минутад цахимаар** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх **тооцохгүй**.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дүгээр хороо, Ф.Энгельсийн гудамж, Улаанбаатар
Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 3 давхар өргөтгөлийн байр. №103 тоот өрөө Утас: 75753047-297.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- | | |
|--|---|
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь TШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТОӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвэл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТОӨЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТОӨЗ 1.1	Захиалагч нь: "Улаанбаатар Дулааны Сүлжээ" ТӨХК.
ТОӨЗ 1.1	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: "Серверийн өргөтгөл шинэчлэлт" Тендер шалгаруулалтын дугаар: ТЗБАХ-2020/07
ТОӨЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй.
ТОӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: " УБДС" ТӨХК-ийн өөрийн хөрөнгө

ТОӨЗ 4.2	<p>Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт, 2. Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт ирүүлэх 3. Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолтыг улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан банк тус бүрээр ирүүлнэ. 4. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ. 5. Гарын үсгийн итгэмжлэлийг маягтын дагуу нотариатоор баталгаажуулан ирүүлнэ. <p>Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ба тендер нээсэн өдрийн байдлаар өр төлбөргүй байх ба түүнийг худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглан шалгана.</p>
ТОӨЗ 4.3	ТОӨЗ-ны 4.2.1 - 4.2.9-д дурьдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдэл ирүүлнэ.
	Б. Тендерийн баримт бичиг
	В. Тендер бэлтгэх
ТОӨЗ 11.1	Тендерийн хэл нь: Монгол хэл байна.
ТОӨЗ 12.1	Тендерт гадаадын этгээд оролцох эрхгүй .
ТОӨЗ 12.1 (в)	Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг МАЯГТ № ТШМ 1-2 маягтын дагуу гаргаж ирүүлнэ.
ТОӨЗ 12.1 (ё)	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Татвар, нийгмийн даатгалын хэлтэс, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэлүүд ирүүлнэ. 2. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ, 3. Тендерийн баримт бичгийн 5, 6 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг хүлээн зөвшөөрч байгаа тухай мэдэгдэл ирүүлнэ, 4. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан тоо хэмжээ бүхий /барааг/ тоног төхөөрөмжийг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ, <p>Дээр заасан материалын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТОӨЗ 13	<ol style="list-style-type: none"> 1. Тендерийн маягтыг тендерийн баримт бичигт заасан МАЯГТ №:ТШМ-1-ийн дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ. 2. Үнийн хуваарийг баталгаажуулан ирүүлнэ. МАЯГТ №: ТШМ-2А, 2Б, 2В-ийн аль тохирохыг сонгох, 3. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ..
ТОӨЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй .

ТОӨЗ 15.5	Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс -ийн хувилбар: “ Incoterms 2010 ”
ТОӨЗ 15.9 (б) (1) and (в) (3)	Бараа хүргэгдэх газар: Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТОӨЗ-ны 15.9.(б).(1) дэх хэсэгт заасан CIP үнэ байна. Энэ үнэнд даатгал, татвар, сургалт, суурилуулалт болон эцсийн цэг хүртэлх бусад бүх зардлууд багтсан байна.
ТОӨЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)	Бараа хүргэгдэх эцсийн цэг: Баянгол дүүрэг. 3-р хороо. Ф.Энгельсийн гудамж “Улаанбаатар Дулааны Сүлжээ” ТӨХК-нд
ТОӨЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна.
ТОӨЗ 16.1	Тендерийн валют: Төгрөг байна.
ТОӨЗ 18.1 (а)	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: Шаардлагагүй.
ТОӨЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2019 оны аудитаар баталгаажсан тайлан ирүүлнэ.
ТОӨЗ 18.1 (г)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын аль нэг жилд төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг үндсэн гүйцэтгэгчээр нийлүүлсэн байх. /Бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, хүлээлгэж өгсөн актын хуулбар,/ Ижил төстэй ажилд гэдэгт техникийн тодорхойлолтонд заасан программ хангамжтай ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг тооцно.
ТОӨЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: Нийлүүлэгч нь баталгаат хугацааны туршид гарсан үйлдвэрийн алдаа, эвдрэл гэмтэл, аливаа асуудлыг бүрэн хариуцна гэсэн албан бичиг ирүүлнэ. Баталгаат засварын хугацаа 12 сараас багагүй байх шаардлагатай ба албан бичгээр баталгаажуулан мэдэгдэх шаардлагатай.
ТОӨЗ 18.1 (е)	Захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл: Шаардлагатай.
ТОӨЗ 18.2 (а)	Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 1 жил буюу 2019 онуудын борлуулалтын дундаж орлого нь төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна.
ТОӨЗ 18.2 (г)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл [1] болон [2] дахь заалтын нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд: 1. Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/ 2. Арилжааны банкны зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой гэсэн тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй/. 3. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн загвар”-ын 3.2.2 /е/-д “Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө = Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө + Санхүүгийн хөрөнгө + Дансны авлага гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэнэ” гэж заасны дагуу тодорхойлно.

ТОӨЗ 18.4	Дотоодын давуу эрхийн зөрүү: Тооцохгүй.
ТОӨЗ 20.1	Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.
ТОӨЗ 22.4	Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцгчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
Г. Тендер ирүүлэх	
ТОӨЗ 23.3 (б)	<p>Тендер хүлээн авах захиалагчийн хаяг:</p> <p>Тендер хүлээн авах этгээд: Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.</p> <p>Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.</p>
ТОӨЗ 23.3 (в)	Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн PDF хэлбэрт шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх бөгөөд баримт бичиг нь гаргацтай, үнэн зөв байна.
ТОӨЗ 24.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2020 оны 05 дугаар сарын 29-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Илгээсэн тендерийн материалыа тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
Д. Тендерийг нээх, үнэлэх	
ТОӨЗ 28.1	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:</p> <p>Байшин, гудамжны нэр: Ф.Энгельсийн гудамж. “УБДС” ТӨХК-ийн байр .</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 3 давхар өргөтгөлийн байрны 1 давхарт 103 тоот өрөө.</p> <p>Аймаг, хот: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг. 3-р хороо.</p> <p>Улс: Монгол Улс.</p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</p> <p>Огноо: 2020 оны 05 дугаар сарын 29-ны өдөр.</p> <p>Цаг: 10 цаг 30 минут.</p>
Е. Гэрээ байгуулах эрх олгох	
ТОӨЗ 41.2	Шалгарсан тендерт оролцогч гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын б-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хугацаанд багтаан түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

--	--

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барааны техникийн тодорхойлолтыг цахим систем дэхь ТЭЗҮ хэсгээс авна уу.

- 1. Барааны тодорхойлолт:** [Барааны тодорхойлолт, техникийн үзүүлэлтийг энд бичнэ.]
- 2. Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [*Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.*] гэж бичнэ
- 3. Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
- 4. Бараа хүргэх газар:** [Барааг хүлээж авах хаягийг бичнэ]
- 5. Бараа нийлүүлэлтийн хугаарь:**

1. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хугаарь

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хуртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө].

Нэр	Барааны тодорхой лолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа <i>(Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)</i>
1	2	3	4	5	6	7	8

1	Техникийн тодорхойл олтод дурьдсан Программ ын лиценз	2	ком	“УБДС” ТӨХК-ийн агуулахад	Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 14 хоног	Гэрээ байгуулснаа с хойш хуанлийн 21 хоног	-
---	---	---	-----	---------------------------	---	--	---

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга Г.Баярсайхан танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [**санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр**] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [**тоо**] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1.	Тодорхойлолт (ГЕН - 1)	1.1.(д)	Захиалагч нь “Улаанбаатар Дулааны Сүлжээ” ТӨХК
		1.1 (ж)	Ажлын талбай нь Баянгол дүүргийн 3 дугаар хороо, “УБДС” ТӨХК-ийн байр
2.	Шалгалт туршилт (ГЕН - 7)	3,1	Ашиглагч “УБДС” ТӨХК-ийн Үйлдвэрлэл хөгжлийн хэлтсийн инженер шалгаж туршилтыг хийнэ.
3.	Барааг хүргэх болон бичиг баримтын бүрдүүлэлт (ГЕН - 9)	9.1	ГЕН-ийн 9 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: “Монгол Улсын гаднаас санал болгосон бараа (жишээлбэл СИП): <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) Даатгалд хамруулсан бод даатгалын гэрчилгээ;3) Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалт туршилтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
		9.4	Энд жагсаасан бичиг баримтыг захиалагчид өгсөн байна. Монгол Улсын дотроос санал болгосон бараа (ИКСБ): <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг захиалагчид өгсөн байна.

- | | | |
|------------------------------------|---|---|
| 4. Даатгал
(ГЕН - 12) | 12.1 | Даатгалын тусгай шаардлага
Нийлүүлэгч өөрөө бүрэн хариуцна. |
| 5. Баталгаат
засвар
(ГЕН-13) | 13.2 | Баталгаат засварын хугацаа барааг хүлээлгэн өгсөн акт үйлдсэнээс хойш 12 сараас багагүй байна. Энэхүү хугацаанд гэрээний үнийн дүнгийн 5 хувийг дуустал барьцаална. |
| 6. Төлбөр (ГЕН - 14) | ГЕН-ийн 14 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: ¹ | |
14. “Захиалагч Монгол Улсын гаднаас санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах журмын дагуу хийнэ:
1. **Урьдчилгаа төлбөр:** Урьдчилгаа төлбөр олгохгүй
 2. **Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:**
Бараа ачигдсаны дараа төлбөр төлөхгүй.
 3. **Барааг хүлээн авахад төлөх төлбөр:** Ирсэн барааны гэрээний үнийн 95 хувьтай тэнцэх дүнг бараа ирснээс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.
 4. **Эцсийн төлбөр:** Эцсийн төлбөрийг баталгаат засварын хугацаа дуусахад төлөх ба бараа эцэслэн хүргэгдсэний дараа нийлүүлэгч гэрээний үнийн дүнгийн 5 хувийн дүнтэй тэнцэх банкны баталгааг захиалагчид гаргаж өгснөөр барьцаалсан мөнгийг урьдчилан олгоно.
- Захиалагч Монгол Улсын дотроос санал болгосон барааны төлбөрийг дараах журмын дагуу хийнэ:
1. **Урьдчилгаа төлбөр:** Урьдчилгаа төлбөр олгохгүй
2. **Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:**
Бараа ачигдсаны дараа төлбөр төлөхгүй
3. **Барааг хүлээн авахад төлөх төлбөр:** Ирсэн барааны гэрээний үнийн 95 хувьтай тэнцэх дүнг бараа ирснээс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.
4. **Эцсийн төлбөр:** Эцсийн төлбөрийг баталгаат засварын хугацаа дуусахад төлөх ба бараа эцэслэн хүргэгдсэний дараа нийлүүлэгч гэрээний үнийн дүнгийн 5 хувийн дүнтэй тэнцэх банкны баталгааг захиалагчид гаргаж өгснөөр барьцаалсан мөнгийг урьдчилан олгоно.

¹ Энд дурдсан заалтууд болон хувиудыг зөвхөн жишээ болгож дурдсан бөгөөд /олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын мөрддөг жишиг/ тухайн бараа нийлүүлэлтийн онцлогт тохируулан өөрчилж болно.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____-наас _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг²;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;

² Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]